



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 31 өдөр

Дугаар А/27

Чойр

Тусгай зөвшөөрлийн хугацааг  
сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, Боловсролын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 42 дугаар зүйлийн 42.4, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны “Улсын тэмдэгтийн хувь, хэмжээ тогтоох тухай” 199 дүгээр тогтоолын 23.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сүмбэр сумын 2 дугаар цэцэрлэгийн сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг 2027 оны 01 дүгээр сарын 14-ны өдрийг хүртэл 5 жилийн хугацаатай сунгасугай.

2. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж, стандартын дагуу чанар, хүртээмжтэй зохион байгуулж, хүний нөөцийн чадавхыг сайжруулан, үр дүнтэй ажиллахыг цэцэрлэгийн эрхлэгч (Ж.Оюунгэрэл)-д үүрэг болгосугай.

3. Цэцэрлэгийн үйл ажиллагаанд нь хяналт тавьж, арга зүй удирдлагаар ханган, гүйцэтгэлийн үр дүнг тооцож ажиллахыг Сүмбэр сумын Засаг дарга (Т.Бат-Эрдэнэ), Боловсрол, шинжлэх ухааны газар (А.Зургаанжин) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Г.БАТЗАМ